

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаяг
эсхүл дээрх QR кодыг ашиглан бусад
танилцуулга, мэдээтэй танилцана уу.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ3-4

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ..... 5

- 1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн: 5
- 1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ: 10

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ 11

- 2.1. Нэгдсэн төсвийн орлого: 11
- 2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага: 15

ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР..... 16

ДӨРӨВ. ГАДААД ХУДАЛДАА 17

- 4.1. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд: 17
- 4.2. Экспорт: 20
- 4.3. Импорт: 24

ТАВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ 27

- 5.1. Мөнгөний нийлүүлэлт: 27
- 5.2. Гадаад валютын албан нөөц: 29
- 5.3. Төлбөрийн тэнцэл: 30

ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ32

- 6.1. Хүн ам, ажил эрхлэлт: 32
- 6.2. Ажилгүйдэл: 32

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ



Эдийн засаг 4.9 хувиар өсжээ. Эдийн засгийн өсөлт 2023 оны жилийн эцсийн байдлаар 7.4 хувьтай гарч байсан бол 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 80.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 13.5 хувь буюу 9.5 их наяд төгрөгөөр, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ-ий хэмжээ 32.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.9 хувь буюу 1.5 их наяд төгрөгөөр тус тус өссөн байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарсан байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 29,589.2 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 30,324.3 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 735.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Төсвийн орлогын хувьд: Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 29,589.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6,294.3 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол тайлант хугацааны орлогын төлөвлөгөөний биелэлт 96.3 хувьтай байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 30,324.3 тэрбум төгрөгт хүрч, 90.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 7,815.3 тэрбум төгрөгөөр буюу 34.7 хувиар нэмэгдсэн байна.

Засгийн газрын нэрлэсэн өр: Засгийн газрын нэрлэсэн өрийн хэмжээ 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 33,429.8 тэрбум төгрөг байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2,664.8 тэрбум төгрөгөөр буюу 8.7 хувиар өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарлаа. 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 27,395.9 сая ам.доллар, экспортын худалдаа 15,783.4 сая ам.доллар, импортын худалдаа 11,612.5 сая ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 4,170.9 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Мөнгөний нийлүүлэлт өслөө. 2024 оны гүйцэтгэлээр мөнгөний нийлүүлэлт 43,334.0 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оноос 5,709.9 тэрбум төгрөг буюу 15.2 хувиар өссөн байна. Өнгөрсөн оноос мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд төгрөгийн харилцах 1,761.9 тэрбум төгрөг буюу 19.7 хувиар, төгрөгийн хадгаламж 4,935.2 тэрбум төгрөг буюу 28.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 12 дугаар сард улсын хэмжээнд 9.0 хувьтай гарч, өмнөх оноос 1.1 нэгж хувиар өссөн байна.

Төлбөрийн тэнцэл: 2024 оны гүйцэтгэлээр урсгал тэнцэл **2,189.8** сая ам.долларын алдагдалтай, харин санхүүгийн тэнцэл **3,158.3** сая ам.долларын ашигтай, хөрөнгийн тэнцэл **171.3** сая ам.долларын ашигтай тус тус гарсан байна. Төлбөрийн тэнцлийн худалдааны тэнцэл алдагдал гарсан хэдий ч хөрөнгийн болон санхүүгийн тэнцлүүд ашигтай гарсан учраас төлбөрийн тэнцэл нийт дүнгээрээ **622.2** сая ам.долларын ашигтайтай гарлаа.

Гадаад валютын нөөц: Нийт албан нөөцийн хэмжээ 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр **5,509.8** сая ам.доллар болж, 2023 оны жилийн эцсээс **588.3** сая ам.доллар буюу **12.0** хувиар өссөн байна.

Валютын ханш: Төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханш 2024 онд **3,390.2** төгрөг, төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш **471.2** төгрөг болж, өмнөх оноос тус тус чангарсан байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өр: 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр хугацаа хэтэрсэн зээл **1,279.1** тэрбум төгрөг болсон байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн **3.5** хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс **1.1** нэгж хувиар буурсан байна.

Чанаргүй зээл: 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр чанаргүй зээлийн хэмжээ **1,873.6** тэрбум төгрөг болж, өнгөрсөн оноос **172.6** тэрбум төгрөг буюу **8.4** хувиар буурчээ. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн **5.1** хувийг эзэлж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ **2.4** нэгж хувиар буурсан байна.

Үнэт цаас: 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр үнэт цаасны арилжаагаар **1,478.5** тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, **1,302.6** сая ширхэг үнэт цаас арилжаалжээ. Өнгөрсөн оноос үнэт цаасны арилжааны гүйлгээ **752.6** тэрбум төгрөгөөр, арилжаалсан үнэт цаас **154.3** сая ширхгээр тус тус нэмэгдсэн байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:


Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ:

2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр бодит ДНБ-ий хэмжээ 2015 оны зэрэгцүүлэх үнээр 32.1 их наяд төгрөг болж, 4.9 хувьд хүрсэн байна.

2021 оны эхний улиралд ДНБ-ий бодит өсөлт 14.8 хувьд хүрч уналтын дараах сэргэлт (V хэлбэрийн сэргэлт) гарсан хэдий боловч энэхүү өсөлт 2022 оны эхний улирал хүртэлх хугацаанд саарч, 2022 оны 2 дугаар улиралд өсөж 2.0 хувьд хүрч байсан бол 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 4.9 хувийн өсөлттэй гарлаа.

График 1-д 2018-аас 2024 оны жилийн эцсийн байдлаарх ДНБ-ий хэмжээ болон мөн хугацааны улирал бүрийн эдийн засгийн бодит өсөлтийн хоорондох хамаарлыг харуулав.

График 1. Нэрлэсэн ДНБ-ий хэмжээ ба ДНБ-ий бодит өсөлт, улирлаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 80.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 13.5 хувь буюу 9.5 их наяд төгрөгөөр, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ-ий хэмжээ 32.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.9 хувь буюу 1.5 их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Эдийн засгийн өсөлтөд үйлдвэрлэл, хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг хувь нэмэр оруулсан байна.

Барилгын салбар 2024 жилийн эцсийн гүйцэтгэлээр 10.4 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 0.3 нэгж хувийг бүрдүүлсэн бол үйлчилгээний бусад салбар 7.8 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 2.2 нэгж хувийг бүрдүүлжээ.


Харин бусад салбаруудын хувьд өмнөх оны мөн үеэс 0.2-19.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, салбаруудын оролцоо /хувь/

Үзүүлэлт	Жилийн эцсийн гүйцэтгэл						
	2018	2019	2020	2021	2022	2023	2024
ДНБ	7.7	5.6	-4.6	1.6	5.0	7.4	4.9
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	6.5	5.3	5.8	-5.5	12.0	-8.9	-28.7
Уул уурхай, олборлолт	5.4	-1.6	-9.9	0.8	-15.3	23.4	10.8
Боловсруулах үйлдвэрлэл	19.5	3.8	3.4	-0.9	6.1	5.1	-1.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	7.0	6.3	1.8	9.4	3.3	5.0	4.8
Барилга	1.8	20.3	-3.2	-22.8	8.2	3.1	10.4
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	0.1	10.9	-12.5	5.8	10.1	6.8	6.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	14.6	4.4	-18.2	-7.3	9.2	39.6	23.1
Мэдээлэл, холбоо	12.1	12.1	5.2	20.7	6.6	17.1	15.5
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	4.8	4.6	-2.6	3.8	5.4	5.8	7.8
Бүтээгдэхүүний цэвэр татвар	20.4	9.6	-9.4	12.2	11.5	6.6	16.1


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 2. Нэрлэсэн ДНБ, өөрчлөлт, оны үнээр, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 3. Бодит ДНБ, өөрчлөлт, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ:

Оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 2024 жилийн эцсийн гүйцэтгэлээр 80.0 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 12.4 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 31.9 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 5.0 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр, өссөн дүнгээр

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2018-IV	2019-IV	2020-IV	2021-IV	2022-IV	2023-IV	2024-IV	Өөрчлөлт (хувиар)
ДНБ	32,582.6	37,839.2	37,883.0	44,702.7	54,877.8	71,201.6	80,048.8	12.4
Эцсийн хэрэглээ	23,019.1	26,627.5	28,570.0	29,580.8	35,422.9	40,524.0	52,840.4	30.4
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	18,883.4	21,667.6	22,648.6	23,085.5	27,927.5	31,362.2	39,803.4	26.9
Төрийн байгууллагын хэрэглээ	4,135.7	4,960.0	5,921.5	6,495.3	7,495.4	9,161.9	13,037.0	42.3
Хөрөнгийн нийт хуримтлал	12,830.4	13,467.7	8,383.4	15,993.2	22,796.5	23,879.9	27,700.1	16.0
Үндсэн хөрөнгийн хуримтлал	8,746.9	10,588.7	8,830.8	11,688.3	16,055.1	17,839.8	21,430.1	20.1
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	4,083.4	2,879.0	-447.4	4,304.9	6,741.4	6,040.1	6,269.9	3.8
Цэвэр экспорт	-3,266.8	-2,256.0	929.6	-871.3	-3,341.6	6,797.6	-491.7	-107.2
Бараа, үйлчилгээний экспорт	18,951.6	22,407.3	21,595.7	25,501.2	35,036.5	53,716.7	55,280.4	2.9
Бараа, үйлчилгээний импорт	22,218.5	24,663.3	20,666.1	26,372.5	38,378.2	46,919.1	55,772.1	18.9

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Хүснэгт 3. Эцсийн ашиглалтын аргаар ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, өссөн дүнгээр

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2018-IV	2019-IV	2020-IV	2021-IV	2022-IV	2023-IV	2024-IV	Өөрчлөлт (хувиар)
ДНБ	26,393.9	27,836.8	26,622.7	27,054.7	28,395.1	30,441.5	31,977.5	5.0
Эцсийн хэрэглээ	20,612.6	22,060.4	23,051.2	22,438.7	24,186.7	26,172.9	29,870.6	14.1
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	16,805.7	17,787.1	18,153.2	17,090.9	18,468.4	20,268.9	22,883.2	12.9
Төрийн байгууллагын хэрэглээ	3,806.8	4,273.3	4,898.0	5,347.8	5,718.2	5,904.0	6,987.3	18.3
Хөрөнгийн нийт хуримтлал	11,037.5	11,057.3	6,561.4	11,857.7	13,182.5	12,733.0	15,553.9	22.2
Үндсэн хөрөнгийн хуримтлал	7,618.3	8,684.8	6,852.5	8,064.1	9,130.6	9,616.8	11,513.2	19.7
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	3,419.3	2,372.4	-291.1	3,793.6	4,051.9	3,116.2	4,040.7	29.7
Цэвэр экспорт	-5,256.2	-5,280.8	-2,989.8	-7,241.7	-8,974.1	-8,464.4	-13,447.0	58.9
Бараа, үйлчилгээний экспорт	12,852.4	14,391.7	13,634.0	11,638.7	15,395.0	20,500.2	20,640.6	0.7
Бараа, үйлчилгээний импорт	18,108.6	19,672.5	16,623.9	18,880.4	24,369.1	28,964.6	34,087.7	17.7

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 4. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад эдийн засгийн бодит өсөлт 5.0 хувиар /эцсийн ашиглалтын аргаар тооцсон/ өсөхөд цэвэр экспорт болон материаллаг эргэлтийн хөрөнгийн өсөлт голлон нөлөөлжээ.

Хүснэгт 4. ДНБ-ий өсөлтийн хувь /өмнөх оны мөн үетэй харьцуулахад/

Бүрэлдэхүүн	Жилийн эцсийн гүйцэтгэл						
	2018	2019	2020	2021	2022	2023	2024
ДНБ	7.6	5.5	-4.4	1.6	5.0	7.2	5.0
Эцсийн хэрэглээ	9.6	7.0	4.5	-2.7	7.8	8.2	14.1
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	11.7	5.8	2.1	-5.9	8.1	9.7	12.9
Төрийн байгууллагын хэрэглээ	1.1	12.3	14.6	9.2	6.9	3.2	18.3
Хөрөнгийн нийт хуримтлал	52.1	0.2	-40.7	80.7	11.2	-3.4	22.2
Үндсэн хөрөнгийн хуримтлал	31.8	14.0	-21.1	17.7	13.2	5.3	19.7
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	131.6	-30.6	-112.3	-1,403.0	6.8	-23.1	29.7
Цэвэр экспорт	243.8	0.5	-43.4	142.2	23.9	-5.7	58.9
Бараа, үйлчилгээний экспорт	6.1	12.0	-5.3	-14.6	32.3	33.2	0.7
Бараа, үйлчилгээний импорт	32.7	8.6	-15.5	13.6	29.1	18.9	17.7

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.2. Нэг ажилтанд ногдох ДНБ

Хөдөлмөрийн бүтээмжийг нэг ажиллагчид ногдох ДНБ-ий хэмжээ буюу хөдөлмөрийн бүтээмжийн түвшингээр тооцно. Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин 2024 оны жилийн эцсийн байдлаар 6.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар буюу 141.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Салбараар нь авч үзвэл, уул уурхайн салбарын бүтээмж 85.8 мянган төгрөг (0.6 хувь)-өөр нэмэгдсэн бол аж үйлдвэр, барилгын салбарын бүтээмж 199.4 мянган төгрөг (5.0 хувь)-өөр, хөдөө аж ахуйн салбарын бүтээмж 288.9 мянган төгрөг (10.2 хувь)-өөр, үйлчилгээний салбарын бүтээмж 102.2 мянган төгрөг (1.8 хувь)-өөр тус тус буурчээ.

Хүснэгт 5. Нэг хүнд ногдох ДНБ буюу бүтээмжийн харьцуулалт

Бүрэлдэхүүн	Жилийн эцсийн гүйцэтгэл							/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт, 2024/2023	
	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин	5,614.0	5,721.1	6,104.4	5,823.1	6,061.5	6,251.3	6,393.1	141.8	2.2
Хөдөө аж ахуй	2,023.4	2,417.8	2,265.4	2,166.9	2,516.2	2,351.9	1,465.2	- 886.8	- 60.5
Уул уурхай, олборлолт	22,132.3	18,422.2	29,116.9	17,009.3	15,625.1	14,478.0	18,537.2	4,059.2	21.9
Аж үйлдвэр, барилга	7,301.2	7,589.0	9,455.1	8,038.6	8,223.3	7,991.1	8,060.9	69.8	0.9
Үйлчилгээ	4,820.6	5,037.6	4,887.6	5,193.1	5,491.1	5,819.7	5,886.6	66.9	1.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 29,589.2 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 30,324.3 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 735.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 6,294.3 тэрбум төгрөг буюу 27.0 хувиар, төсвийн нийт зарлага 7,815.3 тэрбум төгрөг буюу 34.7 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Монгол Улсын нэгдсэн төсөв

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Биелэлт, хувиар	/тэрбум төгрөгөөр/	
					Өөрчлөлт(+/-)	
					2024/2023	
					(3-2)	(3-2)/2
	1	2	3	(3:1)	(3-2)	(3-2)/2
	2024.12	2023.12	2024.12	Гүйц/төл	Дүн	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	30,711.7	23,294.9	29,589.2	96.3	6,294.3	27.0
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	33,573.5	22,509.0	30,324.3	90.3	7,815.3	34.7
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-2,861.8	785.9	-735.1	25.7	-1,521.0	-193.5
ДНБ, оны үнээр	-	70,441.5	79,956.3	-	9,514.8	13.5
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-	1.1	-0.9	-	-2.0	-

Эх сурвалж: : Сангийн яам, Үндэсний статистикийн

2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын бүрдүүлэлт 96.3 хувийн, нийт зарлага 90.3 хувийн гүйцэтгэлтэй гарч, нийт тэнцэл -735.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ -0.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс -2.0 нэгж хувиар буурсан байна.

2.1. Нэгдсэн төсвийн орлого:

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн 29,589.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 27.0 хувиар буюу 6,294.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 4.0 хувь буюу 1,122.5 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрчээ.

Тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал тус бүрээр авч үзвэл улсын төсөв 0.7 хувь буюу 145.9 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 10.8 хувь буюу 861.4 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн төсөв 5.4 хувь буюу 319.3 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 2.0 хувь буюу 39.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж 24.5 хувь буюу 3,942.7 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 45.8 хувь буюу 2,241.9 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сан 30.5 хувь буюу 1,302.4 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 21.4 хувь буюу 338.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 7. Нэгдсэн төсвийн орлогын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС		ҮБС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
Нийт орлого ба тусламжийн дүн	20,652.3	20,471.7	7,994.6	7,133.2	5,893.3	5,574.0	1,964.8	1,925.7	1,288.5	1,341.9
Ирээдүй өв сан	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	789.0	841.4
Хуримтлалын сан	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	499.5	500.6
Тогтворжуулалтын сан	478.6	443.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	20,173.7	20,027.8	7,994.6	7,133.2	5,893.3	5,574.0	1,964.8	1,925.7	0.0	0.0
Татварын орлого	16,918.0	17,012.3	5,956.1	5,665.0	4,718.3	4,399.0	1,964.8	1,925.7	0.0	0.0
Татварын бус орлого	3,255.8	3,015.5	2,038.5	1,468.2	1,175.0	1,175.0	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 92.5 хувийг татварын орлого, 7.5 хувийг татварын бус орлого эзэлж байна.


Хүснэгт 5. Татварын болон татварын бус орлого /хувиар/



Нэгдсэн төсвийн татварын орлого 27,377.4 тэрбум төгрөг болж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 98.1 хувийн биелэлттэй байгаа ба өмнөх оны мөн үеэс 27.4 хувь буюу 5,893.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр Тогтворжуулалтын санд 478.6 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 788.9 тэрбум төгрөг, Хуримтлалын санд 499.5 тэрбум төгрөг хуваарилахаар төлөвлөснөөс Тогтворжуулалтын санд 443.9 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 841.4 тэрбум төгрөг, Хуримтлалын санд 500.6 тэрбум төгрөг хуваарилсан байна. Ирээдүйн өв сангийн хөрөнгө 106.6 хувийн биелэлттэй буюу 52.4 тэрбум төгрөгөөр, Хуримтлалын сангийн орлого 100.2 хувиар буюу 1.0 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн бол, Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлого 7.2 хувийн буюу 34.7 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

Татварын орлого: Татварын орлого: Татварын орлогын 32.8 хувийг орлогын албан татвар, 17.2 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.7 хувийг хөрөнгийн албан татвар, 21.4 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 4.0 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 6.5 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 16.3 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлсэн байна.

График 6. Татварын орлого /тэрбум төгрөгөөр/

Эх сурвалж: Сангийн яам


2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн татварын орлого төлөвлөснөөс 1.9 хувь буюу 534.7 тэрбум төгрөгөөр дутуу биелэсэн байна. Үүнд, орлогын албан татвар 4.2 хувь (359.6 тэрбум төгрөг), онцгой албан татвар 13.5 хувь (130.2 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 1.1 хувь (5.0 тэрбум төгрөг)-аар тус тус давж биелсэн бол нэмэгдсэн өртгийн албан татвар 5.7 хувь (355.9 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 6.7 хувь (337.9 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр, хураамж 4.2 хувь (193.9 тэрбум төгрөг) гадаад үйл ажиллагааны орлого 7.3 хувь (140.2 тэрбум төгрөг), тусгай зориулалтын орлого 5.6 хувь (1.6 тэрбум төгрөг)-аар тус тус дутуу биелжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр орлогын албан татвар 57.5 хувь (3,277.9 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 19.0 хувь (749.2 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 16.6 хувь (65.4 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 22.8 хувь (1,087.4 тэрбум төгрөг), онцгой албан татвар 39.0 хувь (308.1 тэрбум төгрөг), тусгай зориулалтын орлого 22.2 хувь (4.8 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 22.3 хувь (327.0 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр, хураамж 1.7 хувь (73.4 тэрбум төгрөг)-аар тус тус өсжээ.

Татварын бус орлого: 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр татварын бус орлого 2,211.8 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 401.1 тэрбум төгрөгөөр буюу 22.2 хувиар өссөн бол төлөвлөснөөс 587.9 тэрбум төгрөг буюу 21.0 хувиар дутуу төвлөрчээ.

Татварын бус орлогын 80.0 хувийг нийтлэг татварын бус орлого, 19.7 хувийг тусламжийн орлого, 0.3 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогыг бүтцийн хувьд авч үзвэл 36.5 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 13.4 хувийг газрын тосны орлого, 12.1 хувийг бусад орлого, 11.1 хувийг торгуулийн орлого, 11.0 хувийг хүүгийн орлого, 11.0 хувийг хувьцааны ноогдол ашиг, 4.5 хувийг навигацийн орлого, 0.5 хувийг түрээсийн орлого тус тус бүрдүүлж байна.

График 7. Татварын бус орлогын бүтэц, хувиар



Эх сурвалж: Сангийн яам

Төлөвлөгөөтэй харьцуулахад гадаад хандив тусламжийн орлого 142.4 тэрбум төгрөгөөр, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 9.6 тэрбум төгрөгийн дутуу биелэлтэй байна.

Нийтлэг татварын бус орлогоос төсөвт байгууллагын өөрийн орлого 178.3 тэрбум төгрөг, хүүгийн орлого 4.3 тэрбум төгрөг, түрээсийн орлого 3.1 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн бол бусад орлого 526.8 тэрбум төгрөг, газрын тосны орлого 47.1 тэрбум төгрөг, хувьцааны ноогдол ашгийн орлого 42.8 тэрбум төгрөг, торгуулийн орлого 5.3 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрчээ.

2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 33,573.1 тэрбум төгрөг төлөвлөснөөс 90.3 хувийн зарцуулалтай буюу 3,248.8 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл 7,815.3 тэрбум төгрөг буюу 34.7 хувиар өсөж, 30,324.3 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн зарлага

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	ӨО-ны мөн үеийн /2023.12/	2024 оны жилийн эцсийн гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,509.0	33,573.1	30,324.3	90.3	-3,248.8
НИЙТ ЗАРЛАГА	22,279.6	33,463.2	29,949.9	89.5	-3,513.3
УРСГАЛ ЗАРДАЛ	17,091.4	23,077.0	22,025.5	95.4	-1,051.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,085.4	10,104.0	9,404.1	93.1	-699.9
ХҮҮ	1,150.0	1,222.4	1,195.0	97.8	-27.4
ТАТААС	579.7	1,022.6	954.5	93.3	-68.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,276.3	10,728.0	10,471.8	97.6	-256.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,188.2	10,386.3	7,924.4	76.3	-2,461.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	229.4	109.9	374.4	340.7	264.5

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн урсгал зардал 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.9 хувиар буюу 4,934.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нэгдсэн төсвийн зарлагын 72.6 хувь буюу 22,025.5 тэрбум төгрөг нь урсгал зардал, үүний дотор 47.5 хувийг урсгал шилжүүлэг, 42.7 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 5.4 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 4.3 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бараа, ажил үйлчилгээний зардал 4,318.7 тэрбум төгрөг, урсгал шилжүүлэг 195.5 тэрбум төгрөг, татаас 374.9 тэрбум төгрөг, зээлийн үйлчилгээний төлбөр 45.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Түүнчлэн хөрөнгө оруулалтын зардал 2,736.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн өмнөх оны мөн үеэс 27.0 хувь буюу 6,294.3 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 34.7 хувь буюу 7,815.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, төсвийн зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 7.7 нэгж хувиар их гарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1,521.0 тэрбум төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ.

ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “Засгийн газрын өр”-ийг тодорхойлсон, тухайлбал 4.1.8.а-д өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг, 4.1.8.б-д хууль болон гэрээнд заасны дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгааны дүнг” гэж тодорхойлсон. Засгийн газрын дотоод өр гэж өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газраас бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг, Засгийн газрын гадаад өр гэж Монгол Улсын Засгийн газрын эдийн засгийн харьяат бус аливаа этгээдэд төлөх өрийн хэрэгслээр үүсгэгдсэн төлбөрийн үүргийг тус тус ойлгоно.

Хүснэгт 9. Засгийн газрын өр /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	Жилийн эцсийн гүйцэтгэл								
	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023*	2024*
I.Засгийн газрын дотоод өр (өрийн хэрэгслээр)	5,796.0	3,461.9	1,564.7	1,399.6	1,136.6	920.6	1,035.5	234.1	400.5*
Үнэт цаас	5,488.8	3,461.9	1,564.7	1,399.6	1,136.6	920.6	1,035.5	234.1	400.5*
II.Засгийн газрын гадаад өр1 (өрийн хэрэгслээр)	12,363.8	16,857.8	18,865.6	20,443.5	24,848.1	24,644.8	29,619.1	30,319.5	30,292.9*
Үнэт цаас	5,380.5	7,701.6	7,664.5	7,927.2	8,354.0	8,175.6	9,359.8	9,371.7	8,632.1*
Зээл	6,983.3	9,156.2	11,201.1	12,516.3	16,494.1	16,469.2	20,259.3	20,947.8	21,660.8
III.Засгийн газрын бусад өр	4,120.4	2,432.0	1,936.7	2,072.0	1,910.6	1,550.4	1,290.5	211.4	2,736.4
Засгийн газрын өрийн баталгаа	3,451.5	1,663.8	1,130.7	1,076.3	1,060.4	876.5	778.7	30.9	178.0
Барих-шилжүүлэх концесс	668.9	768.2	806.0	995.7	850.2	673.9	511.8	180.5	-
Орон нутгийн зээллэг	-	-	-	-	-	-	-	-	2,558.4*
Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдэл (I+II+III)	22,280.2	22,751.7	22,367.0	23,915.1	27,895.3	27,115.8	31,945.1	30,765.0	33,429.8
ЗГ-ын өр/ДНБ	93.1	81.2	68.6	63.2	74.5	62.3	59.3	43.7	41.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Сангийн яам*

Засгийн газрын өрийн хэмжээ 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 33,429.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,664.8 тэрбум төгрөгөөр буюу 8.7 хувиар өссөн байна. Үүнд; Засгийн газрын дотоод үнэт цаас 116.4 тэрбум төгрөгөөр буюу 71.1 хувиар, Засгийн газрын бусад өр 2,525.0 тэрбум төгрөг буюу 12.9 дахин өссөн бол Засгийн газрын гадаад өр 26.6 тэрбум төгрөгөөр буюу 0.1 хувиар буурсан байна. Энэ нь Засгийн газрын үнэт цаас өмнөх оны мөн үеэс 739.6 тэрбум төгрөгөөр буюу 7.9 хувиар буурсантай холбоотой байна.


Засгийн газрын өрийн хэмжээг ковидын өмнөх үе буюу 2019 оны мөн үетэй харьцуулж үзэхэд 9,514.7 тэрбум төгрөгөөр буюу 39.8 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь Засгийн газрын гадаад өрийн 9,849.4 тэрбум төгрөг буюу 48.2 хувийн өсөлт (гадаад үнэт цаас 704.9 тэрбум төгрөг буюу 8.9 хувь, гадаад зээл 9,144.5 тэрбум төгрөг буюу 73.1 хувь)-тэй холбоотой байна.

ДӨРӨВ. ГАДААД ХУДАЛДАА

2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр Монгол Улс 152 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 27,395.9 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 2,958.8 сая ам.доллар буюу 12.1 хувиар тус тус өссөн байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ нэмэгдэж, гадаад худалдааны тэнцэл сүүлийн 10 гаруй жилийн турш ашигтай гарлаа. Гадаад худалдааны тэнцэл 2014 онд 537.7 сая ам.долларын ашигтай байсан бол 2024 онд 4,170.9 сая ам.долларт хүрсэн байна.

График 8. Гадаад худалдааны үзүүлэлт, 2018-2024 оноор /сая ам.доллар/



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

4.1. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд

2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 27,395.9 сая ам.доллар, экспортын худалдаа 15,783.4 сая ам.доллар, импортын худалдаа 11,612.5 сая ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 4,170.9 сая ам.долларын ашигтай гарсан байна.

2018-2024 онд экспортын дундаж өсөлт 14.5 хувь, импортынх 12.0 хувь байгаа нь гадаад худалдааны нийт бараа эргэлт болон гадаад худалдааны ашиг нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Ялангуяа, 2021-2024 онд экспортын дундаж өсөлт 19.5 хувь, импортынх 19.3 хувь байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад 2024 оны гүйцэтгэлээр экспорт 596.5 сая ам.доллар буюу 3.9 хувиар, импорт 2,362.3 сая ам.доллар буюу 25.5 хувиар тус тус өсчээ.

Хүснэгт 10. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлт, 2020-2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр

Үзүүлэлт	Жилийн эцсийн гүйцэтгэл					/сая ам.доллар/ Өөрчлөлт	
	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нийт эргэлт	12,875	16,087	21,243	24,437	27,396	2,958.8	12.1
Экспорт	7,576	9,241	12,539	15,187	15,783	596.5	3.9
Импорт	5,299	6,846	8,704	9,250	11,613	2,362.3	25.5
Тэнцэл	2,277	2,396	3,834	5,937	4,171	-1,765.7	-29.7

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2024 онд гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн оноос 1,765.7 сая ам.доллар буюу 29.7 хувиар буурч, 4,170.9 сая ам.долларын ашигтай гарсан. Импортыг экспортоор нөхөх коэффициент 2023 онд 164.2 хувь, 2024 онд 135.9 хувь байна.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл: 2024 оны гүйцэтгэлээр валютын төлбөртэй экспорт нийт экспортын орлогын 99.1 хувь, валютын төлбөртэй импорт нь нийт импортын худалдааны 96.2 хувийг тус тус эзэлж байна.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2024 оны гүйцэтгэлээр 4,473.6 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оноос 1,692.3 сая ам.доллар буюу 27.4 хувиар буурсан байна. Өнгөрсөн оноос валютын төлбөртэй экспортын орлого 646.5 сая ам.доллар буюу 4.3 хувь, валютын төлбөртэй импорт 2,338.8 сая ам.доллар буюу 26.5 хувиар тус тус нэмэгджээ.

Хүснэгт 11. Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл


Үзүүлэлт	Жилийн эцсийн гүйцэтгэл			Харьцуулсан хувь (2024/2023)
	2022	2023	2024	Хувь
НИЙТ БАРАА ЭРГЭЛТ	21,243.0	24,437.1	27,395.9	12.1
А.Экспорт	12,538.6	15,186.9	15,783.4	3.9
А1.Валютын төлбөртэй бараа	12,462.9	14,997.0	15,643.5	4.3
Валютын төлбөртэй экспортын нийт экспортод эзлэх хувь	99.4	98.7	99.1	-
В.Импорт	8,704.4	9,250.2	11,612.5	25.5
В1.Валютын төлбөртэй бараа	8,336.0	8,831.1	11,169.9	26.5
Валютын төлбөртэй импортын нийт импортод эзлэх хувь	95.8	95.5	96.2	-
С. Тэнцэл (А-В):	3,834.2	5,936.6	4,170.9	-29.7
D. Импортыг экспортоор нөхөх коэффициент ((A/B)*100)	144.0	164.2	135.9	-

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Экспорт, импортын жилийн өсөлт: Экспорт болон импортын жилийн өсөлтийн хурдыг 3 сарын гулсах дундаж (2011.01-2024.12)-аар тооцон үзлээ.

2013 онд Оюутолгойн уурхайн төсөл эхэлж, олборлолт, борлуулалт хийснээр экспортын тоо хэмжээ 2014-2015 онуудад өссөн. 2020 оны эхний 5 сарыг эс тооцвол 2014 оны 10 сараас хойш өнөөг хүртэл гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан байна.

График 9. Гадаад худалдааны үзүүлэлтүүдийн өөрчлөлт



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Хөрш орнууд (ОХУ, БНХАУ) Монгол Улсын гадаад худалдаанд томоохон үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, 2024 оны гүйцэтгэлээр хөрш орнууд нийлээд Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 80.2 хувь, экспортын 91.9 хувь, импортын 64.2 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс:

- БНХАУ-тай хийсэн худалдаа нь Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 69.5 хувь (19.0 тэрбум ам.долл), экспортын 91.3 хувь (14.4 тэрбум ам.долл), нийт импортын 40.0 хувь (4.6 тэрбум ам.долл)-ийг эзэлжээ.
- ОХУ-ын хувьд гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 10.7 хувь (2.9 тэрбум ам.долл), экспортын 0.6 хувь (100.7 сая ам.долл), нийт импортын 24.3 хувь (2.8 тэрбум ам.долл)-ийг эзэлж байна.
- БНХАУ-тай хийсэн худалдаа 9,763.8 сая ам.долларын ашигтай, ОХУ-тай хийсэн худалдаа 2,721.1 сая ам.долларын алдагдалтай байна.

Бусад улс оронтой хийсэн худалдаа гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 19.8 хувь, экспортын 8.1 хувь, импортын 35.7 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 12. Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Улс орон	Үзүүлэлт	Эзлэх хувь /2024.12/	Жилийн эцсийн гүйцэтгэлээр			Өөрчлөлт (+/-)	
			2022	2023	2024	2024.12/2023.12	
						Дүн	Хувь
БНХАУ	Нийт эргэлт	69.5	14,133.8	17,652.9	19,048.0	1,395.1	7.9
	Экспорт	91.3	11,061.6	13,903.2	14,405.9	502.7	3.6
	Импорт	40.0	3,072.2	3,749.7	4,642.1	892.4	23.8
	Тэнцэл	-	7,989.4	10,153.5	9,763.8	-389.7	-3.8
ОХУ	Нийт эргэлт	10.7	2,704.9	2,499.0	2,925.5	426.5	17.1
	Экспорт	0.6	93.4	112.7	100.7	-12.0	-10.6
	Импорт	24.3	2,611.5	2,386.3	2,824.8	438.5	18.4
	Тэнцэл	-	-2,518.1	-2,273.6	-2,724.1	-450.5	19.8
Бусад	Нийт эргэлт	19.8	4,404.3	4,285.1	5,422.5	1,137.3	26.5
	Экспорт	8.1	1,384.0	1,171.1	1,276.4	105.3	9.0
	Импорт	35.7	3,020.3	3,114.0	4,146.1	1,032.1	33.1
	Тэнцэл	-	-1,636.3	-1,942.9	-2,869.7	-926.8	47.7

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо

4.2. Экспорт:

2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр экспортын худалдаа 15,783.4 сая ам.доллар болж, өнгөрсөн оноос 596.5 сая ам.доллар буюу 3.9 хувиар өссөн байна.

2024 онд эрдэс бүтээгдэхүүний экспорт 13,769.8 сая ам.доллар болж, өмнөх оноос 623.4 сая ам.доллар буюу 4.7 хувиар өссөн байна. 2024 онд эрдсийн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жин 87.2 хувь байна. Харин эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт 2024 онд 2,013.6 сая ам.долларт хүрсэн байна.

Хүснэгт 13. Экспорт, бүлгээр /2020-2024/

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Жилийн эцсийн гүйцэтгэлээр					Өөрчлөлт	
	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нийт экспорт	7,576.3	9,241.1	12,538.6	15,186.9	15,783.4	596.5	3.9
Үүнээс:							
1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт	5,256.0	7,510.4	10,543.3	13,146.5	13,769.8	623.4	4.7
Эрдэс бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь	69.4	81.3	84.1	86.6	87.2	-	-
2. Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	2,320.3	1,730.7	1,995.3	2,040.4	2,013.6	-26.9	-1.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүнд нүүрс, зэсийн баяжмал, алт, төмрийн хүдэр, түүхий газрын тос, жоншны баяжмал, цайрын баяжмал зэрэг бүтээгдэхүүн хамаарч байна.

Нийт экспортын орлогын 55.1 хувийг нүүрс, 21.0 хувийг зэсийн баяжмал, 5.7 хувийг алт, 3.8 хувийг төмрийн хүдэр, 2.0 хувийг боловсруулаагүй нефть, 2.0 хувийг жоншны баяжмал тус тус эзэлж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад нүүрс, газрын түүхий тос, цайрын баяжмал болон молибдены баяжмалаас бусад эрдсийн бүтээгдэхүүний экспортын орлого өссөн байна.

Хүснэгт 14. Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Гол нэр төрлийн бараа	Жилийн эцсийн гүйцэтгэлээр					Өөрчлөлт	
	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нүүрс (сая.т)	28.7	16.1	31.8	69.6	83.8	14.1	20.3
Зэсийн баяжмал(мян.т)	1,395.1	1,282.5	1,453.3	1,525.0	1,695.4	170.4	11.2
Алт (тн)	30.5	17.3	19.7	11.7	11.6	- 0.1	-0.5
Төмрийн хүдэр (сая.т)	8.2	7.1	4.7	5.7	7.5	1.8	31.5
Боловсруулаагүй нефть (сая.барр)	4.1	4.3	2.6	4.7	4.1	-0.7	-13.9
Жоншны баяжмал (мян.т)	678.9	644.3	387.7	1,087.8	1,369.1	281.3	25.9
Цайрын баяжмал (мян.т)	134.1	112.6	141.2	150.5	126.2	-24.3	-16.2
Молибдены баяжмал (мян.т)	6.4	7.3	6.5	6.4	6.0	- 0.4	-6.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 15. Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний экспортын орлого


Гол нэр төрлийн бараа	Экспортод эзлэх хувь	Жилийн эцсийн гүйцэтгэлээр					Өөрчлөлт	
		2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нүүрс	55.1	2,126.6	2,774.1	6,503.2	8,898.5	8,698.0	-200.5	-2.3
Зэсийн баяжмал	21.0	1,778.0	2,899.9	2,734.8	2,625.7	3,319.1	693.4	26.4
Алт	5.7	1,787.7	1,004.5	1,127.4	738.0	899.4	161.4	21.9
Төмрийн хүдэр	3.8	640.0	952.2	391.0	444.7	597.6	152.8	34.4
Боловсруулаагүй нефть	2.0	150.9	273.4	241.8	364.7	322.1	-42.6	-11.7
Жоншны баяжмал	2.0	156.3	144.0	110.5	272.4	318.5	46.2	16.9
Цайрын баяжмал	1.2	167.7	176.4	283.3	220.0	183.3	-36.7	-16.7
Молибдены баяжмал	0.6	40.7	82.4	87.2	120.5	96.1	-24.5	-20.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:


Зэсийн баяжмал: 2024 онд 1,695.4 мянган тонн зэсийн баяжмал экспортолж, экспортын орлого 3,319.1 сая ам.доллар болж, экспортын орлого өнгөрсөн оноос 693.4 сая ам.доллар буюу 26.4 хувиар өссөн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад зэсийн баяжмалын экспортын тоо хэмжээ 170.4 мянган тонн буюу 11.2 хувиар, зэсийн баяжмалын хилийн үнэ 13.7 хувиар тус тус өссөн нь экспортын орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

График 10.Зэсийн баяжмалын экспортын өөрчлөлт



Төмрийн хүдэр: 2024 оны гүйцэтгэлээр 7.5 сая.тонн төмрийн хүдэр экспортолж, 597.6 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Өнгөрсөн онтой харьцуулахад төмрийн хүдрийн экспортын орлого 34.4 хувь буюу 152.8 сая ам.доллараар өссөн байна. Үүнд төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ 1.8 сая тонн буюу 31.5 хувиар, үнэ 2.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ. Экспортын дундаж үнэ 79.6 ам.доллар болж өнгөрсөн оноос 2.2 хувиар өссөн.

График 11. Төмрийн хүдрийн экспортын өөрчлөлт




Алт: 2024 оны гүйцэтгэлээр 11.6 тонн алт экспортолж, 899.4 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өнгөрсөн онтой харьцуулахад алтны экспортын орлого 131.4 сая ам.доллар буюу 21.9 хувиар өссөн байна. Өнгөрсөн оноос алтны үнэ 22.4 хувиар өссөн нь алтны экспортын орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Жоншны баяжмал: 2024 оны гүйцэтгэлээр жоншны баяжмалын экспортын тоо хэмжээ 1,369.1 мянган тонн-д хүрч, 318.5 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Жоншны баяжмалын биет хэмжээ өнгөрсөн оноос 25.9 хувь буюу 281.3 мянган тонноор өссөн нь жоншны экспортын орлого өсөхөд голлон нөлөөлжээ.

Нүүрс: 2024 оны гүйцэтгэлээр 83.8 сая тонн нүүрс экспортолж, 8.7 тэрбум ам.долларын экспортын орлого олжээ. Өнгөрсөн онтой харьцуулахад экспортын биет хэмжээ 14.1 сая тонн буюу 20.3 хувиар өссөн. Нүүрсний экспортын орлого нэмэгдэхэд нүүрсний экспортын тоо хэмжээ өссөн нь голлон нөлөөлжээ. 2024 онд дундажаар сард 6.9 сая тонн нүүрс экспортжээ. 2023 онтой харьцуулахад нүүрсний хилийн дундаж үнэ 18.8 хувиар буурч, 103.8 ам.долл/тн-оор борлуулсан байна.

График 12. Нүүрсний экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Боловсруулаагүй нефть: 2024 оны гүйцэтгэлээр 4.1 сая баррель боловсруулаагүй нефть экспортолж, 322.1 сая ам.долларын орлого олсон байна. Өнгөрсөн онтой харьцуулахад боловсруулаагүй нефтийн экспортын орлого 42.6 сая ам.доллар буюу 11.7 хувиар буурсан байна. Үүнд боловсруулаагүй нефтийн тоо хэмжээ 0.6 сая баррелиар буурсан нь голлон нөлөөлсөн.

Цайрын баяжмал: 2024 оны гүйцэтгэлээр цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ 126.2 мянган тонн болж, 183.3 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Өнгөрсөн онтой харьцуулахад цайрын баяжмалын биет хэмжээ 16.2 хувь буюу 24.3 мянган тонноор буурсан нь цайрын баяжмалын экспортын орлого 36.7 сая ам.доллар буюу 16.7 хувиар буурахад нөлөөлжээ.

4.3. Импорт:

2024 оны гүйцэтгэлээр импортын худалдаа 11,612.5 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 25.5 хувь буюу 2,362.2 сая ам.доллараар өссөн байна.

2024 оны гүйцэтгэлээр нийт импортын 21.1 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 78.9 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний импорт 2,444.6 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 304.2 сая ам.доллар буюу 14.2 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 9,167.9 сая ам.доллар болж, өнгөрсөн оноос 2,058.0 сая ам.доллар буюу 28.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 18. Импорт, бүлгээр /2020-2024 он/

Үзүүлэлт	Жилийн эцсийн гүйцэтгэлээр					Өөрчлөлт	
	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нийт импорт	5,298.9	6,845.5	8,704.4	9,250.2	11,612.5	2,362.2	25.5
Үүнээс:							
1. Эрдэс бүтээгдэхүүний импорт	1,007.2	1,338.6	1,960.3	2,140.3	2,444.6	304.2	14.2
Эрдэс бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь	19.0	19.6	22.5	23.1	21.1	-	-
2. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	4,291.7	5,506.9	6,744.1	7,109.9	9,167.9	2,058.0	28.9

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2024 оны гүйцэтгэлээр нийт импортын 30.5 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 42.7 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 8.0 хувийг аж үйлдвэрлэлийн орц, 18.6 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлж байна.

Хүснэгт 19. Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл

/сая ам.доллар/


Бүтээгдэхүүн	Жилийн эцсийн гүйцэтгэлээр						Өөрчлөлт (сая ам.долл)
	2022		2023		2024		2024/ 2023
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	
Хэрэглээ	2,686	30.9	2,692	29.1	3,546	30.5	854.0
- Түргэн эдэлгээтэй	1,501	17.2	1,363	14.7	1,605	13.8	242.0
- Удаан эдэлгээтэй	1185	13.6	1329	14.4	1941	16.7	612.0
Хөрөнгө оруулалт	3,307	38.0	3,820	41.3	4,955	42.7	1,135.0
- Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	1,987	22.8	2,411	26.1	3,271	28.2	860.0
- Барилгын материал	1002	11.5	1100	11.9	1288	11.1	188.0
- Хөрөнгө оруулалтын бусад бараа	318	3.7	309	3.3	396	3.4	87.0
Аж үйлдвэрлэлийн орц	966	11.1	852	9.2	933	8.0	81.0
Нефтийн бүтээгдэхүүн	1,724	19.8	1,869	20.2	2,162	18.6	293.0
- Дизель	960	11.0	1110	12.0	1296	11.2	186.0
- АИ-92, 95	535	6.1	509	5.5	639	5.5	130.0
- А80 ба бусад	229	2.6	250	2.7	227	2.0	-23.0
Бусад	21	0.2	18	0.2	17	0.1	-1.0
Нийт дүн	8,704	100.0	9,251	100.0	11,613	100.0	2,362.0

Эх сурвалж: Монголбанк

2023 онтой харьцуулахад 2024 онд импортын худалдаа нэмэгдэхэд хөрөнгө оруулалт 1,135.0 сая ам.доллар, хэрэглээ 854.0 сая ам.доллар, нефтийн бүтээгдэхүүн 293.0 сая ам.доллар, аж үйлдвэрийн орц 81.0 сая ам.доллороор тус тус өссөн нь нөлөөлжээ. Үүний дотор машин, механик тоног төхөөрөмж, эд анги 860.0 сая ам.доллар, дизель түлш 186.0 сая ам.доллар, барилгын материал 188.0 сая ам. доллар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 612.0 сая ам.доллороор тус тус нэмэгдсэн байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт нь өнгөрсөн оноос 293.0 сая ам.доллороор өссөн байна. Дизель түлшний импорт 186.0 сая ам.доллороор нэмэгджээ. 2024 оны гүйцэтгэлээр нефтийн бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 112.7 ам.дол/баррель байна.

График 13. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ /ам.доллар/ баррель/



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТАВ. МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ**5.1. Мөнгөний нийлүүлэлт:**

2024 оны гүйцэтгэлээр мөнгөний нийлүүлэлт 43,334.0 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оноос 5,709.9 тэрбум төгрөг буюу 15.2 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оноос мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд төгрөгийн харилцах 1,761.9 тэрбум төгрөг буюу 19.7 хувиар, төгрөгийн хадгаламж 4,935.2 тэрбум төгрөг буюу 28.8 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 20. Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Жилийн эцсийн гүйцэтгэлээр			Өөрчлөлт (+/-)	
				2024/2023	
	2022	2023	2024	Дүн	Хувь
Мөнгөний нийлүүлэлт (M2)	29,664.8	37,624.1	43,334.0	5,709.9	15.2
Мөнгө M1	7,201.3	9,853.1	11,687.4	1,834.3	18.6
Төгрөгийн харилцах	6,370.2	8,947.6	10,709.5	1,761.9	19.7
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	831.1	905.5	977.9	72.4	8.0
Бараг мөнгө	22,463.5	27,770.9	31,646.6	3,875.7	14.0
Төгрөгийн хадгаламж	12,606.7	17,125.2	22,060.4	4,935.2	28.8
Валютын хадгаламж	4,910.0	4,998.8	4,856.1	- 142.7	-2.9
Валютын харилцах	4,946.8	5,646.9	4,730.1	- 916.8	-16.2
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө	1,089.2	1,151.7	1,222.2	70.5	6.1

Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 37.0 их наяд төгрөг болж, өнгөрсөн оноос 9.6 их наяд төгрөг буюу 35.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 21. Зээлийн өрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Жилийн эцсийн гүйцэтгэлээр			Өөрчлөлт (+/-)	
				2024/2023	
	2022	2023	2024	Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	22,241.7	27,380.9	37,049.9	9,669.0	35.3
-Хэвийн зээл	19,086.2	24,061.9	33,897.2	9,835.2	40.9
-Хугацаа хэтэрсэн зээл	1,128.7	1,272.7	1,279.1	6.3	0.5
-Чанаргүй зээл	2,026.8	2,046.2	1,873.6	-172.6	-8.4
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	5.1	4.6	3.5	-	-
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	9.1	7.5	5.1	-	-

Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 61.0 хувь нь иргэдийнх, 36.5 хувь нь хувийн хэвшлийн байгууллагынх эзэлж байна. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2024 оны эцсийн гүйцэтгэлээр 33.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 9.8 их наяд төгрөг буюу 40.9 хувиар өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 91.5 хувийг хэвийн зээл, 5.1 хувийг чанаргүй зээл, 3.5 хувийг хугацаа хэтэрсэн зээл эзэлж байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл: 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр хугацаа хэтэрсэн зээл 1,279.1 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оноос 6.3 тэрбум төгрөг буюу 0.5 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.5 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 1.1 нэгж хувиар буурсан байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ: 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр чанаргүй зээлийн хэмжээ 1,873.6 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оноос 172.6 тэрбум төгрөг буюу 8.4 хувиар буурчээ. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.1 хувийг эзэлж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ 2.4 нэгж хувиар буурсан байна.

Үнэт цаас: 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр үнэт цаасны арилжаагаар 1,478.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 1,302.6 сая ширхэг үнэт цаас арилжаалжээ. Өнгөрсөн оноос үнэт цаасны арилжааны гүйлгээ 752.6 тэрбум төгрөгөөр, арилжаалсан үнэт цаас 154.3 сая ширхгээр тус тус нэмэгдсэн байна. 2024 оны эцсийн гүйцэтгэлээр хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны нийт үнэлгээний дүн 13.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 1.4 их наяд төгрөг буюу 11.6 хувиар өссөн байна. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2024 оны эцэст 50,277.7 нэгж болж, өмнөх оноос 11,723.8 нэгжээр өссөн байна.

Валютын ханш: Төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханш 2024 онд 3,390.2 төгрөг болж, өмнөх оноос 75.6 төгрөгөөр чангарсан байна. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 471.2 төгрөг болж, өмнөх оноос 18.5 төгрөгөөр мөн чангарсан байна.

График 14. АНУ-ын доллар ба БНХАУ-ын юанийн ханш, /2024 оны байдлаар/ /төгрөгөөр/




Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээний үнийн индекс:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 12 сард улсын хэмжээнд 9.0 хувьтай гарч, өмнөх оноос 1.1 нэгж хувиар нэмэгдсэн байна.

2020-2022 онд тээвэр логистикийн хүндрэл, нийлүүлэлтийн саатлаас үүдэлтэйгээр хүнсний бүтээгдэхүүн, эрчим хүч, үйлчилгээний үнэ өссөн нь дэлхийн улс орнуудад инфляц өндөр байхад голлон нөлөөлсөн. Монгол Улсын хувьд мөн шалтгааны улмаас удаан хугацаанд буюу 25 сарын туршид инфляц 10-аас дээш хувьтай байснаа 2023 оны 9 дүгээр сараас хойш 2024 оны эцэс хүртэлх хугацаанд 10-аас доош түвшинд байна.

График 15. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, сар бүрийн өөрчлөлт, хувиар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

5.2. Гадаад валютын албан нөөц:

Нийт албан нөөцийн хэмжээ 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 5,509.8 сая ам.доллар болж, 2023 оны жилийн эцсээс 588.3 сая ам.доллар буюу 12.0 хувиар өссөн байна.

График 16. Нийт гадаад валютын албан нөөц /сая ам.доллараар/



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2024 оны 12 дугаар сард 5,509.8 сая ам.доллар болж нийт импортын 5.7 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрсэн байна.

Хүснэгт 22. Гадаад валютын албан нөөц ба импорт


/сая ам.доллар/

№	Үзүүлэлт	Жилийн эцсийн гүйцэтгэлээр				
		2020	2021	2022	2023	2024
1	Нийт импорт	5,298.9	6,845.5	8,704.4	9,250.2	11,612.5
2	Гадаад валютын нийт нөөц	4,534.2	4,366.1	3,399.6	4,921.5	5,509.8
3	Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/	10.3	7.7	4.7	6.4	5.7

Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар

Худалдан авсан алт: Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2024 онд 16.5 тонн болж, 2023 оноос 1.4 тонноор буурсан байна. 2016-2024 оны хугацаанд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 15.2-23.6 тонн хооронд байна. Үүний дотор 2020 онд буюу Ковидын үед хамгийн өндөр худалдан авалт хийсэн буюу 23.6 тонн байна.

График 17. Монгол банкны худалдан авсан алтны хэмжээ, 2013.12-2024.12 гүйцэтгэл /тонн/



Эх сурвалж: Монголбанк

5.3. Төлбөрийн тэнцэл:

Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2024 оны 12 сарын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 2,189.8 сая ам.долларын алдагдалтай, харин санхүүгийн тэнцэл 3,158.3 сая ам.долларын ашигтай, хөрөнгийн тэнцэл 171.3 сая ам.долларын ашигтай тус тус гарсан байна.

Төлбөрийн тэнцлийн худалдааны тэнцэл алдагдал гарсан хэдий ч хөрөнгийн болон санхүүгийн тэнцлүүд ашигтай гарсан учраас төлбөрийн тэнцэл нийт дүнгээрээ 622.2 сая ам.долларын ашигтай гарлаа.


2024 оны 12 сарын байдлаар урсгал тэнцэл алдагдалтай гарахад анхдагч орлого 2,533.2 сая ам.долларын алдагдалтай байсан нь голлон нөлөөлсөн.

Хүснэгт 23. Төлбөрийн тэнцэл, 2022-2024 оны жилийн эцсийн гүйцэтгэл

Үзүүлэлт	Жилийн эцсийн гүйцэтгэлээр			Өөрчлөлт
	2022	2023	2024	Дүн
I. Урсгал Тэнцэл	- 2,303.5	121.2	- 2,189.8	- 2,311.0
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	- 1,122.5	1,956.3	- 109.9	- 2,066.2
В. Анхдагч орлого	- 1,615.0	- 2,232.8	- 2,533.2	- 300.4
С. Хоёрдогч орлого	433.9	397.7	453.0	55.3
II. Хөрөнгийн тэнцэл	154.2	134.6	171.3	36.7
III. Санхүүгийн тэнцэл	- 1,643.9	- 1,476.6	- 3,158.3	- 1,681.7
IV. Алдаа болон орхигдуулга	- 221.9	- 275.8	- 517.7	- 241.9
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	- 727.2	1,457.0	622.2	- 834.8

Эх сурвалж: Монголбанк

График 18. Төлбөрийн тэнцэл, 2017-2024 он, /сая ам.доллар/



Эх сурвалж: Монголбанк

ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН БАЙДАЛ


6.1. Хүн ам, ажил эрхлэлт

2024 оны жилийн гүйцэтгэлээр улсын хэмжээнд 60.2 мянган хүүхэд шинээр төрсөн байна. 2024 онд нийт ажиллах хүчний тоо 1,428.8 мянга болж, 2023 оны жилийн эцсээс 61.5 мянгаар нэмэгдсэн байна. Ажиллах хүчнээс 1,353.4 мянган хүн нь ажилтай, 75.4 мянган иргэд нь ажилгүй хүмүүс байна. Өнгөрсөн онтой харьцуулахад ажилтай иргэдийн тоо 58.7 мянгаар нэмэгдэж, ажилгүй хүмүүсийн тоо 2.8 мянгаар мөн өссөн байна. 2024 оны гүйцэтгэлээр ажиллах хүчний оролцооны түвшин 62.2 хувь болж, өмнөх оноос 2.7 нэгж хувиар өссөн байна. Хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 71.4 хувь, эмэгтэйчүүдийнх 53.7 хувь байна. Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 58.9 хувь байна. Мөн 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам 869.2 мянга байна.

6.2. Ажилгүйдлийн түвшин

2024 оны 12 дугаар сард улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 5.3 хувьтай болж, 2023 оны жилийн эцэстэй харьцуулахад 1.4 нэгж хувиар өссөн, харин өмнөх улирлаас 0.8 нэгж хувиар буурсан байна.

График 19. Ажилгүйдлийн түвшин, хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС